АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Батцэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2025/4/-НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.Open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор Э.Нямсүрэн<br>Цахим хаяг: nyamsurene@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ........ 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 5

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........ 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**........ 9

**3.1** Албан шаардлага........ 9

**3.2 Зөвлөмж**........ 10

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 10

**5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ** ........ 11

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.25 № 170
танай ____________-ны №____________-т

БАТЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Батцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд сумын төсөвт 20 нэр төрлийн орлогоор 464,344.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 619,676.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө нийт дүнгээр 133.5 хувиар давж биелсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус төсвийн төвлөрүүлэн захирагч нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,092,047.2 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,746,621.1 мянган

төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 345,426.4 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Энэ нь ОНХС, ХХС-нд төлөвлөсөн 265,074.3 мянган төгрөг зарцуулагдаагүй, төсөвт байгууллагуудын үлдэгдэл 80,352.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Батцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 79.5 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 778,514.0 | 939,783.3 |
| **31** | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 439,746.5 | 512,875.0 |
| **33** | АВЛАГА | 288,282.9 | 310,697.5 |
| **35** | БАРАА МАТЕРИАЛ | 50,484.6 | 59,985.4 |
| **36** | НӨӨЦИЙН БАРАА | 0.0 | 56,225.4 |
| **2** | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,531,389.4 | 3,088,276.2 |
| **39** | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,531,389.4 | 3,088,276.2 |
| **39200** | Биет хөрөнгө | 2,489,908.1 | 3,051,219.9 |
| **39300** | Биет бус хөрөнгө | 41,481.3 | 37,056.3 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 3,309,903.4 | 4,028,059.4 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 0.0 | 44,000.0 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.0 | 44,000.0 |
| **41300** | **Өглөг** | 0.0 | 44,000.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 3,309,903.4 | 3,984,059.4 |
| **51** | Засгийн газрын хувь оролцоо | 3,309,903.4 | 3,984,059.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 418,921.1 | 418,921.1 |
| **51200** | Хуримтлагдсан үр дүн | 2,863,022.9 | 3,537,178.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 27,959.4 | 27,959.4 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 3,309,903.4 | 4,028,059.4 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган  төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,474,794.8 | 2,650,063.0 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 453,752.3 | 742,467.8 |
| **110** | Орлогын албан татвар | 259,586.4 | 595,986.5 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 259,523.4 | 595,876.5 |
| **1102** | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 63.0 | 110.0 |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 107,095.5 | 78,088.5 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 87,070.5 | 68,392.8 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 277,748.8 | 746,615.0 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 277,748.8 | 746,615.0 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 743,293.8 | 1,160,980.2 |
| **II** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,013,460.8 | 1,551,993.9 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,013,460.8 | 1,551,993.9 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 989,877.9 | 1,484,888.2 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 520,037.8 | 769,601.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,114.6 | 98,450.2 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,280.6 | 217,779.3 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 68,020.7 | 87,842.6 |
| **2105** | Нормативт зардал | 600.0 | 0.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,536.2 | 32,404.1 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 3,592.0 | 4,750.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 144,831.0 | 40,385.7 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 161,865.0 | 233,674.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,582.9 | 67,105.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 461,334.0 | 1,098,069.0 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 250,185.5 | 423,913.0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 211,148.5 | 674,156.1 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2023оны 12-р сарын 31** | **2024 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,281,113.1 | 1,963,367.6 |
| **11** | ТАТВАРЫН ОРЛОГО | 453,752.3 | 742,467.8 |
| **110** | Орлогын албан татвар | 259,586.4 | 595,986.5 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 259,523.4 | 595,876.5 |
| **1102** | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 63.0 | 110.0 |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 107,095.5 | 78,088.5 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 87,070.5 | 68,392.8 |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 21,493.7 | 19,407.8 |
| **1181** | Газрын төлбөр | 53,543.3 | 38,869.3 |
| **1182** | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 12,033.5 | 10,115.7 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 84,067.0 | 59,919.6 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 84,067.0 | 59,919.6 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 743,293.8 | 1,160,980.2 |
| **II** | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 874,149.2 | 1,363,286.2 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 874,149.2 | 1,363,286.2 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 850,566.3 | 1,289,164.1 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 514,991.7 | 769,601.6 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,129.9 | 98,450.2 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,781.8 | 217,269.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 60,426.8 | 54,191.6 |
| **2105** | Нормативт зардал | 600.0 | 1,600.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,466.0 | 32,428.1 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 3,592.0 | 4,750.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 147,418.9 | 43,550.3 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,159.2 | 67,323.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,582.9 | 74,122.1 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 406,963.9 | 600,081.4 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 250,062.2 | 526,952.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 250,062.2 | 526,952.9 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 250,062.2 | 526,952.9 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | -250,062.2 | -526,952.9 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 156,901.7 | 73,128.5 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 282,844.8 | 439,746.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 439,746.5 | 512,875.0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,098,754.9 | 3,098,754.9 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,098,754.9 | 3,098,754.9 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 211,148.5 | 211,148.5 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,309,903.4 | 3,309,903.4 |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,309,903.4 | 3,309,903.4 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,309,903.4 | 3,309,903.4 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 674,156.1 | 674,156.1 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 3,984,059.4 | 3,984,059.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,092,047.50 | 1,746,621.10 | 345,426.40 | 83.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,399,484.90 | 1,322,708.14 | 76,776.76 | 94.51 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,323,412.90** | **1,253,673.52** | **69,739.38** | **94.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **811,877.00** | **769,601.63** | **42,275.37** | **94.79** |
| 210101 | Үндсэн цалин | 756,272.00 | 502,537.42 | 253,734.58 | 66.45 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 245,580.69 | -245,580.69 | #DIV/0! |
| 210104 | Урамшуулал | 25,005.00 | 15,483.52 | 9,521.48 | 61.92 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 30,600.00 | 6,000.00 | 24,600.00 | 19.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **102,838.50** | **98,450.15** | **4,388.35** | **95.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,379.70 | 68,704.28 | 1,675.42 | 97.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,114.70 | 7,620.38 | 494.32 | 93.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,491.80 | 5,589.69 | 902.11 | 86.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,622.90 | 1,624.94 | -2.04 | 100.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,229.40 | 14,910.86 | 1,318.54 | 91.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **221,080.60** | **217,269.33** | **3,811.27** | **98.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 61,575.60 | 63,403.76 | -1,828.16 | 102.97 |
| 210302 | Түлш, халаалт | 148,405.00 | 146,612.89 | 1,792.11 | 98.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,100.00 | 7,252.67 | 3,847.33 | 65.34 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **61,127.00** | **53,996.58** | **7,130.42** | **88.34** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,977.00 | 3,620.60 | 356.40 | 91.04 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,010.00 | 23,545.35 | 1,464.65 | 94.14 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,324.00 | 6,324.00 | 0.00 | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 792.00 | 576.00 | 216.00 | 72.73 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 19,476.00 | 14,853.90 | 4,622.10 | 76.27 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,548.00 | 5,076.74 | 471.26 | 91.51 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,600.00** | **1,600.00** | **0.00** | **100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,600.00 | 1,600.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **35,100.00** | **34,828.00** | **272.00** | **99.23** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500.00 | 2,500.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,600.00 | 32,328.00 | 272.00 | 99.17 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,750.00** | **4,750.00** | **0.00** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,750.00 | 4,750.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **53,039.80** | **41,258.71** | **11,781.09** | **77.79** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,769.80 | 39,151.99 | 11,617.81 | 77.12 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600.00 | 600.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250.00 | 250.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 370.00 | 370.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150.00 | 150.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150.00 | 150.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 750.00 | 586.72 | 163.28 | 78.23 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **32,000.00** | **31,919.12** | **80.88** | **99.75** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,000.00 | 31,919.12 | 80.88 | 99.75 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **76,072.00** | **69,034.62** | **7,037.38** | **90.75** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **15,750.00** | **9,666.75** | **6,083.26** | **61.38** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 15,750.00 | 9,666.75 | 6,083.26 | 61.38 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **60,322.00** | **59,367.88** | **954.13** | **98.42** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,822.00 | 45,822.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,500.00 | 13,545.88 | 954.13 | 93.42 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **512,562.60** | **423,912.96** | **88,649.64** | **82.70** |
| 223001 | Бусад хөрөнгө | 512,562.60 | 423,912.96 | 88,649.64 | 82.70 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **180,000.00** | **0.00** | **180,000.00** | **0.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 180,000.00 | 0.00 | 180,000.00 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,092.05** | **1,721.16** | **370.89** | **82.27** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,567.48** | **1,662.95** | **-95.47** | **106.09** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,278.79 | 1,374.25 | -95.47 | 107.47 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 288.70 | 288.70 | 0.00 | 100.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **524.56** | **58.21** | **466.36** | **11.10** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 195.60 | 58.21 | 137.39 | 29.76 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 328,963.80 | 0.00 | 328,963.80 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 334,649,.4 | 334,649,.4 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 309,185.1 | 309,185.1 | 0.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **64.00** | **62.00** | **2.00** | **96.88** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2.00** | **2.00** | **0.00** | **100.00** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **31.00** | **30.00** | **1.00** | **96.77** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **143,617.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **43,617.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **38,530.48** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **195.00** |

| | | |
|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 195.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,291.56** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,291.56 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **36,043.92** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,043.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,087.50** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **5,087.50** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,087.50 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **100,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **100,000.00** |
| 221001 | Их засвар | 100,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **143,617.98** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **143,617.98** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 32,613.92 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 102,291.56 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,712.50 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **28,146.6** мянган төгрөгийн зөрчил[1] илэрч зөрчил арилгуулах 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүллээ.
Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 28,146.6 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 31,380.7 мянган төгрөгөөс бага байгаа тул “**Өөрчлөлтгүй”**дүгнэлт өглөө.

**3.1** Албан шаардлага

Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 5 зээлдэгчид олгосон 21,390.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг хугацаанд нь барагдуулаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 дүгээр зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*__Шийдвэрлэсэн__*: Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Төсвийн орлоготой холбоотой асуудал

*__Илрүүлэлт:__* Сумын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлээр 2 нэр төрлийн орлого 6,756.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогын сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

*Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орлоготой холбоотой | 1 | 6,756.6 | - | - | | | 1 | 6,756.6 | - | - | - | - |
| ХХС | 1 | 21,390.0 | - | - | 1 | 21,390.0 | | | | | | |
| Дүн | 2 | 28,146.6 | | | | 21,390.0 | 1 | 6,756.6 | | | | |

# 5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ИТХ | 2 | 5,795.0 | | | 2 | 5,795.0 | | | | | | |
| ЗДТГ | 2 | 372,362.5 | | | 2 | 372,362.5 | | | | | | |
| **Нийт дүн** | **4** | **378,157.5** | | | **4** | **378,157.5** | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ИТХ | | 0 | | 0 | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | 0 | | 0 | | | | |